

ШИВЭЭТ УУЛЫН ТОМ ЧУЛУУН БАЙГУУЛАМЖ

З.БАТСАЙХАН

¹МУИС, НШУС, Археологи-Антропологийн тэнхим
e-mail: batsaihan@num.edu.mn

Түлхүүр үг: Түрэг, Хөшөө цайдам, Хүн чулуу түрэгийн том байгууламж, цогцолбор дурсгал, Куль-тегин, Билгэ хаан

ТОВЧ АГУУЛГА. Шивээ толгойн том були нь Архангай аймгийн Хашаат сумын нутагт Билгэ хаан, Куль-тегин нарын цогцолбор дурсгалаас өмнө зүгт 3 км зайтай уулын оройд орших бөгөөд газар дээрх були нь дотоод болон гадаад хоёр хэсгээс бүтнэ. Гадаад хэсэг нь 70 м голчтой, дотоод хэсэг нь тэг дөрвөлжин 36 х 36 м хэмжээтэй, хуудсан чулууг нягт нямбай өрж хийсэн 2 давхар ханатай 100-180 см өндөр байгууламж болно. Малталтын явцад чулуун дараасын дороос толгой, цээж нь хугарч салсан сайн хадгалагдсан завиан суусан хүн чулуу гарлаа.

Дөрвөлжин чулуун ханын зузаан ойролцоогоор 400 см бөгөөд дотор талын зайд асар их гал түлсэн ул мөр байх боловч булины нүхний толбо байхгүй ажээ. Учир иймээс уг були нь газар доорх бунхант оршуулга байх боломжтой бөгөөд Зүүн Түрэгийн II хаант улсын Билгэ болон Куль-тегин мэтийн томоохон сурвалжит язгууртны були байж болох юм. Үүнээс гадна уг байгууламж нь монголд судлаж байгаагүй шинэ хэв шинжийн дурсгал мөн гэдгийг онцлон дурдах хэрэгтэй.

Хашаатын Шивээ толгой нь Хөшөө Цайдам дахь Билгэ хаан, Культегин нарын цогцолбор дурсгалаас зүүн урд зүгт 3 км, эртний монголын нийслэл Хархорумаас 40 км зайтай оршино. Уулын оройгоос урагш 40-50 км, баруун зүгт 20-30 км, хойт зүгт 40-50 км хүртэл алсын бараа харагдах тэр хавийн хамгийн өндөр орой дээр байгуулжээ. Шивээ толгойн баруун талаар 2 км зайтай Хөгшин Орхон урсана. Шивээ толгойн дээрх байгууламж нь хадны сүг зураг бүхий өндөрлөгийн зүүн талд 100 м орчим зайтай газарт орших бөгөөд 70 м голчтой, зөв дугуй хэлбэртэй, 5-7 м өндөр, голдоо жигд бус, өм цөм хонхортой бөгөөд жижгэвтэр элсэн чулуугаар байгуулсан том булш юм. Социализмын үед Хашаат сумын зарим барилга, байгууламж, мөн тус сумын малчин өрх айлын малын хашаа, хороо болон Хөгшин Орхоны гармыг боох зэрэгт Шивээ толгойн булшны хэдэн зуун куб метр чулууг аж ахуйн зориулалтаар зөөж ашигласан нь анхны хэмжээ үлэмж багасахад нөлөөлсөн нь ойлгомжтой. Мөн уг байгууламжийн урд тал, баруун талын хонхор болон түүний баруун хормой, бэлээр гол төлөв жижиг, дугуй хэлбэрийн 70 орчим булш, Шивээ толгойн орой дээрх хадан дээр янгир болон руни бичгийн үсэг мэт зарим нэг тамга тэмдэг сийлжээ.

З.БАТСАЙХАН

Урд өмнө нь дээрхийн ижил хэмжээний том байгууламжуудыг монголд малтан судлаж байсан туршлага үгүй учир малталтын зөв аргыг сонгох асуудал ихээхэн чухал байлаа. Юуны өмнө дээрх байгууламж дээр ертөнцийн зүг чигийн дагуу босоо болон хэвтээ тэнхлэг байгуулж, 4 секторт хуваагаад зүүн хойд талаас нь цагийн зүүний дагуу 1-4 хүртэл дугаарлав. Малталтын ажилд 5 тонн даацтай шанага бүхий трактор ашиглалаа. Малталтыг 1-р сектороос эхлэн хормойноос нь шуух маягаар эхэлсэн бөгөөд тэгэхдээ олон талаас нь ажиглан үргэлжлүүлж байв. Уг байгууламжийн хормойноос дотогш чулууг цэвэрлэхэд 15 м орчимд нимгэн хуудсан чулууг маш жигд өрсөн хана мэт байгууламж илэрснээр уг байгууламжийн бүтэц, зохион байгуулалтын зарим хэсэг нилээд тодорхой болж ирэв. Ханыг дагуулан малталтыг цааш үргэлжлүүлэхэд 1-р секторын зүүн хойд булан орчим, чулуун дундаас боржин чулуугаар хийсэн, завилж суусан толгойгүй хүн чулууны их бие гарлаа. Ийм маягаар зүүн ханыг бүхэлд нь цэвэрлэж дуусахад 36 м урт хуудсан чулууг жигд давхарлан өрсөн хана болох нь тодорхой боллоо. Хананы өндөр голдоо 180 см өндөр, хоёр захруугаа аажмаар намссаар 90-100 см өндөр болж байна. Байгууламжийн үндсэн дотоод бүтэц, зохион байгуулалт нэгэнт тодорхой болсон учир илэрсэн булангуудыг дагуулан цэвэрлэж, үлдсэн ханануудыг ил гаргав. Ханануудын өндрийн хэмжээ эхний ханатай ойролцоо ижил өндөртэй байлаа. Урд хананы зүүн хэсгээс өмнө илэрсэн хүн чулууны толгой олдсон бөгөөд түүнийг эх бие дээр нь давхарлан тавихад эвээрээ яг таарч байлаа. Хананы бүтэц, зохион байгуулалтыг мэдэх зорилгоор зүүн ханан дээр 2 м өргөн, баруун ханан дээр 4 м өргөн хэсэг газрыг цэвэрлэхэд хоёр давхар хана болох нь тогтоогдсон. Эхний буюу гадна талын хана 150 см орчим зузаан, хоёр дахь буюу дотор хананы өргөн тодорхой сайн мэдэгдэхгүй боловч ойролцоогоор мөн 150 см орчим өргөн байна. Гэхдээ хоёр дахь хана нь нэгдүгээр хананаасаа 30-60 см өндөр байлаа. Ханануудын урт 36-37 м, хоорондоо 30-50 см зөрөөтэй. Ханыг ойролцоогоор 4 м өргөнтэй гэж үзээд дотор талын чулууг эртний өнгөн хөрс хүртэл цэвэрлэхэд урд хана, баруун хана мөн зүүн хананы хэсэг газарт маш их түүдэг асаасан ул мөр илэрсэн бөгөөд зарим газарт уулын чулуулаг шатаж бутарсан байна. Үүнээс гадна урд хананы дагуу 1-3 см орчим зузаан түлэгдсэн үе тод харагдаж байна. Хананы доторх талбайг цэвэрлэсний хойно ажиглаж үзэхэд талбайн зүүн хэсэг, баруун урд хэсэг, баруун хойд хэсэгт уулын үндсэн чулуулаг ил гарч зөвхөн 4-р секторын зүүн урд хэсэг 2-р секторын босоо тэнхлэгийн дагуу хэсэгт цайвар шар болон улаавтар шар өнгийн чулуугүй хөрс ажиглагдаж байлаа. Энд 3 хэсэг газарт 3-5 м урттай, 1 м өргөн сорилтын шуудуу татаж үзэхэд 80-100 см гүн болоход ямар нэгэн толбо байгаа шинж тэмдэг байхгүй, байгалийн тогтоц үе давхараа болох нь тодорхой боллоо. Өөрөөр хэлбэл дөрвөлжин хашлагат байгууламжийн дотор талбайд булшны нүх гэхээр толбо илрээгүй билээ.

Уг байгууламжийн доторх ханыг өрж дууссаны хойно гаднах ханыг давхарлан байгуулжээ. Ханын дотор асар их гал түлсэн байх бөгөөд урд хананы дотор талын ёроолын дагуу 3 газарт 15 см орчим голчтой, 50 см орчим урт мод зоосон байлаа. Мөн ийм мод 4-р секторт малтсан шуудууны хананд илэрсэн. Ийнхүү ханыг барьж дууссаны дараа гол болон гадна талыг чулуу овоолон

дүүргэжээ. Тэгэхдээ доторх хоосон зай болон ханын гадна талд гол төлөв том хад чулууг ашигласны зэрэгцээ зарим газарт хавтгай чулууг нилээд нягт нямбай өрж овоолсон байна. Эцэст нь бага хэмжээний чулуу дээгүүр нь асгаж орхисон бололтой байдал ажиглагдаж байна. Мөн үүнтэй ижил дотоод бүтэц, зохион байгуулалт Шивээт Улааны чулуу нь нурсан зарим хэсэгт ажиглагдаж байгаа бөгөөд эдгээр дурсгалууд нь Зүүн Түрэгийн II хаант улсын үед холбогдох нэгэн ижил хэв шинжийн дурсгалууд болох нь тэдгээрийн бүтэц, зохион байгуулалтын нийтлэгээс харагдаж байна.

Малталтаас гарсан хүн чулуу

Малталтаас олдсон хүн чулуу нь хөлөөс толгой хүртэл 160 см өндөр, газарт суулгах хэсэг нь 50 см урт бөгөөд доод хэсгийг зөвхөн нарийсгах төдийхнөөр засаж янзалжээ. Хүн чулууг зүүн гараа өвдөг дээрээ тавьж, баруун гараараа цээжиндээ хундага атган, завилан суугаа байдалтай хийжээ. Хүн чулууны толгой буюу нүүрийг ихээхэн бодит байдалтай дүрсэлсэн байх бөгөөд дөлгөөн, ихэмсэг харцтай, сахалгүй, жавжиндаа инээмсэглэл тодруулсан монгол төрхтэйгээр дүрсэлсэн байна. Хүн чулууны дээлийг түрэгийн томоохон дурсгалууд дээр түгээмэл ажиглагддаг цэцгэн хээгээр чимэглэсэн байх бөгөөд ханцуй, зах, дотуур цамц, дээлийн энгэр гэх мэтийг маш нарийн урлажээ. Олон тоног, найман унжлага бүхий агсарга бүс зүүсэн байх бөгөөд баруун ташаанд хавтага, зүүн ташаанд мөн хавтага мэт ямар нэг зүйлийг зүүжээ. Гутал нь нүүдэлчдийн хэв загвар бүхий гутал бололтой. Харин малгай нь нилээд сонирхолтой бөгөөд энэ нь хятад мэтийн дорно зүгийн улс орны хаад, түшмэдийн өмсдөг зулай хэсэг нь нам, ар тал нь өндөр тэр малгайтай төстэй харагдаж байна. Хөшөө нар салхи, бороо усанд элэгдэж хэмхрээгүй, маш сайн хадгалагдсанаас үзвэл хийсний дараа удалгүй эвдэж нурааснаас болсон бололтой.

Хэрэглэгдэхүүнээс үзвэл хүн чулуудыг завилсан, сөхөрсөн, бохирсон болон зогсоо байдлаар дүрсэлсэн байх бөгөөд нийт судлагдсан хүн чулуудаас завилан суусан байдлаар хийсэн 30 гаруй хүн чулуу олдсоны 20 нь монголд бүртгэгджээ (Баяр, 1997:26). Энэхүү завилан суусан хүн чулууудын ихэнх нь Налайх дахь Тоньюкук, Онгийн голын дурсгал болон Орхоны савд орших Хөшөө Цайдам, Шивээт Улаан гэх зэрэг томоохон алдартай цогцолбор дурсгалын бүрэлдэхүүнд багтаж байгаа нь тэдгээрийг түрэгийн хаад, сурвалжтанууд болохыг дам зааж буйн нэг илрэл хэмээн үзэж болох юм.

Шивээ толгойн дурсгалтай хамгийн ижил төстэй дурсгал бол Тарнайн голын завилан суусан хүн чулуу бүхий том булш болно. Тарнайн голын хүн чулуу нь хэмжээгээр Шивээ толгойнхоос бага боловч дээл, хувцсан дээр сийлсэн хээ, бүс зэрэг гол шинж тэмдгээрээ адил бөгөөд, харамсалтай нь толгойгүй учир нүүр, царай, малгайг харьцуулах боломжгүй юм. Өмнө өгүүлснээр Шивээ толгойн хүн чулууны нүүрийг илэрхий монгол төрхтэй гаргасан байдаг бөгөөд Хөшөө Цайдамын малталтаас илэрсэн Культегины толгойтой ихээхэн төстэй харагдаж байна. Эдгээр хүн чулуудыг нэгтгэж байгаа нэг гол шинж нь сахалгүй, дөлгөөн,

тайван, ихэмсэг байдлаар дүрсэлсэнд оршино. Гэтэл одоо мэдэгдэж буй хүн чулуудын багагүй хэсгийг өмнө өгүүлсэн хүн чулуудаас илт ялгарахуйц сахалтай, том нүдтэй, их хөмсөгтэй, өндөр хамартай, нилээд догшин дүр төрхтэй, эрс өөр дүрсэлсэн байдгаас үзвэл түрэгийн хүн амын бүрэлдэхүүн гетероген шинжтэй нүүдэлчид байсныг харуулж байж болох юм. Гэхдээ түрэгийн хаант улсын ноёлох хэсэг нь монгол төрхтөний хэв шинжтэй байжээ гэж болохоор байна.

Уг дурсгал нь Хөшөө Цайдамаас 3 км орчимд байгаа нь дээрх хоёр дурсгал нэгэн цаг үед холбогдох нь эргэлзээгүй бөгөөд тэдгээрийн хооронд ямар нэг шууд харилцаа холбоо байж болохоос ба бидний урьдчилан таамаглаж байгаагаар Зүүн Түрэгийн жанжин 731 онд нас барсан Культегин, 734 онд нас барсан Билгэ хаан нарын бунхант оршуулга байж болох талтай. Тэднийг нас барахад хятадын Тан улсын эзэн хаан Сюань Цзун өөрийн гараар бичсэн эмгэнэлийн захидлыг элчээр дамжуулан илгээхийн зэрэгцээ оршуулгын ажилд оролцох урчууд болон 500 цэргийг илгээсэн бөгөөд Культегин, Билгэ хаан нарт зориулсан тахилгын байгууламжуудыг ойролцоогоор нэг жилийн дараа дуусгаж, ёслол, төгөлдөр нээж байжээ. Энэхүү томоохон оршуулгын болон тахилгын байгууламжийг барьж, байгуулахад Хөх түрэгийн олон ард иргэд ихээхэн хүчин зүтгэл гаргасан нь дээрх байгууламжуудын цар хэмжээнээс харагдаж байна. Нөгөө талаас судлаачдын дунд хаад язгууртнуудыг чандарладаг байсан мэтээр ойлгосоор иржээ. Гэтэл руни бичгийн зарим дурсгалд тухайлбал Ар ханангийн түрэг бичээст Күл-тархан ноёныг нас барахад эртний нүүдэлчдийн заншил ёсоор хойлог хийж оршуулсан тухай өгүүлдэг бол (Л.Болд, 1990:17), Куль-чурт босгосон гэрэлт хөшөөний бичээсний 24-р мөрөнд “...чур тегин, түүний хойноос дөрвөн тегин ирж Ышбара цэцэн Кул-чурыг оршуулсан...” гэжээ. Энд оршуулсан гэж зориуд цохон тэмдэглэснийг бодвол тухайн үеийн зан заншилыг мэдэхэд чухал хэрэглэгдэхүүн болох нь эргэлзээгүй (Л.Болд, 1990:40-43).



Зураг 1. Шивээ толгойн були

ШИВЭЭТ УУЛЫН ТОМ ЧУЛУУН БАЙГУУЛАМЖ



Зураг 2. Баруун талаас авсан зураг




Зураг 3. Булины зүүн хана



Зураг 4. Булины зүүн хойд өнцөг



Зураг 5. Булины баруун ханын давхарлаж өрсөн хэсгийг цэвэрлэсний дараах байдал



Зураг 6. Шивээ толгойн малталтаас гарсан хүн чулуу

Шивээ толгойн байгууламжийг малтан, судлах ажил эхний шатандаа байгаа ба дараачийн зорилт нь бунхант оршуулгын үүд буюу ам, хонгилыг олоход чиглэх бөгөөд энэ нь нилээн нарийн төвөгтэй, бэрхшээлтэй ажил болох нь ойлгомжтой. Тэрчлэн дээрх хэв шинжийн булшийг монгол болон тухайн бүс нутагт малтан, судалсан туршлага үгүй билээ. Харин хятадын Тан улсын бунхант оршуулгуудын гадаад шинж төрхтэй төстэй байгааг хойшид нягтлан судлууштай.

Шивээт толгойн баруун суганы жижиг булшууд

Шивээт толгойн баруун суганд овгор дугуй, хавтгай дугуй болон том чулууг тойруулан өрсөн, ойролцоогоор 4 м орчим голчтой жижиг булшууд цөөнгүй бий. Эдгээр булшуудын он цагийг тодорхойлох зорилгоор хоёр булшийг сонгон малтсан. Энэ газар нь урагшаа харсан, хоёр талаараа хадтай жижиг толгой бүхий хотгор энгэр бөгөөд урд талдаа гүн жалгатай. Хөгшин Орхоноос зүүн тийш 2 км орчим зайтай газар оршино.

1-р булш. Талбайн дээд хэсэгт орших 450 х 390 м хэмжээтэй, зөв бус зууван дугуй хэлбэртэй, булшны гадаад байгууламж зарим хэсэгтээ багагүй эвдэрч, өөрчлөгджээ. Чулуун дараасыг авсны хойно талбайн төвд цэвэрлэж үзэхэд уртрагийн дагуу тодорхой хэлбэр дүрсгүй нүх гарсан бөгөөд 90 см гүнд хүний гавлын хэсэг болон мөчдийн яснууд энэ тэндээс гарч эхэлсний зэрэгцээ 4 талт төмөр хадаас, төмөр зэв, үйсний хэсэг зэрэг эд өлгө тодорхой байрлалгүй, янз бүрийн газруудаас гарлаа.



Зураг 7. Хашиаатын Шивээ толгойн 1-р булинаас гарсан авсны төмөр хадаас, зэв, хутга болон гархи



Зураг 8. Шивээт толгой. 2-р були



Зураг 9. Шивээт овоо. 2-р були. Хонины толгой дээр тавьсан төмөр амгай



Зураг 10. Шивээт овоо. 2-р були. Хүзүүн дэх С хэлбэрийн хүрэл эдлэл

ШИВЭЭТ УУЛЫН ТОМ ЧУЛУУН БАЙГУУЛАМЖ



Зураг 11. Хашиатын Шивээ толгойн 2-р булнаас гарсан С хэлбэрийн хүрэл эдлэл, нүүрс, үйсний хэсэг

Ясны хадгалалт дунд зэрэг, хүйс болон зүг чигийг тогтоох боломжгүй. Тэрчлэн хэд хэдэн удаа тоногдож, булшны дотоод зохион байгуулалт, нүхний хэлбэр бүхэлдээ эвдэрсэн бөгөөд түүнийг дагуулан малтахад дээрхийн адил энд тэндээс төмөр хутга, 4 талт хуяг нэвтлэгч зэв, хавтгай зэв, жижиг, дугуй төмөр арал, модны наалдацтай төмөр хадаасууд дахин гарсан юм. Булшны нүхний хэмжээ урт нь ойролцоогоор 220 х 150 см. Булшнаас олон тооны модны наалдацтай төмөр хадаас олдож байгаагаас үзвэл модон австай байсан бололтой. Гэвч авс байсныг батлах модон хийц огт байсангүй. Иймэрхүү маягийн төмөр хадаас Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын Ачаат уул, Асгат сумын Шарга уул зэрэг газраас гадна оросын Чита мужийн Оловянная өртөөний орчим малтсан дундад эртний монгол булшнаас олдож байжээ (Ковычев, 1988:137). Дурдсан хэв шинжийн зэвүүд нь Монгол, Өвөр Байгаль болон Казахстан зэрэг газар нутгийн XIII-XIV зууны үеийн археологийн дурсгалуудаас түгээмэл олддог зэр зэвсгийн зүйл юм.

2-р булш. 1-р булшнаас урд зүгт 10-аад метрийн зайтай газарт орших 400 х 350 см хэмжээтэй, нягт овгор чулуун дараастай, зууван дугуй хэлбэртэй булш. Булшны чулуун дараасыг цэвэрлэсний дараа эртний өнгөн хөрснөөс 20 см гүнд зүүн хойд, баруун урд зүгийг чиглэсэн нүхний толбо илрэв. Нүхийг дагуулан малтахад 90 см гүнд толгойг нь зүүн хойд зүгт чиглүүлэн, хөлийг жийлгэн тэнэгэр

байдлаар тавьсан оршуулга илрэв. Хүний хавирга, нуруу болон хоёр гарын бугалга, шууны ясны ихэнх хэсэг нь ялзарч үгүй болсон ба хөлийн яс анатомийн байрлалаар үлджээ. Хөл талд нь хонины толгойг хушууг нь баруун зүг харуулан тавьж, дээр нь том цагирган зуузайтай, төмөр амгай тавьсан байлаа. Хүзүүнд нь нэг үзүүртээ торгон давуугаар ороож байсан бололтой үлдэгдэлтэй, С үсэг маягийн хүрэл эдлэл байлаа. Богийн шилбэний бололтой хоёр хугархай яс, зүүн шилбэний хажууд тавьсан байжээ. Хүйсийг тогтоох боломжгүй. Булшны нүх гонзгой, зууван хэлбэртэй 2 м урт, өргөн нь толгой талаараа 60 см, хөл талаараа 40 см. Он цаг тогтоох тодорхой хэрэглэгдэхүүн гарсангүй.

2-р булшнаас олдсон том, цагирган зуузайтай төмөр амгай нь Өмнөд Сибирьт IX зуунаас хожуугүй дэлгэрсэн гэж үздэг (Киселев, 1949:362) бол А.А.Гаврилова IX-X зуунд холбогдоно гэжээ (1965:113). Энэ хэв шинжийн дөрөө МЭ I мянганы эцэс, II мянганы эхэн үеийн Тува, Хакас, Дорнод Казахстан, Дорнод европт дэлгэрчээ (Неверов, 1982:114).

НОМ ЗҮЙ

- Баяр Д.* 1997. Монголын төв нутаг дахь түрэгийн хүн чулуу. УБ
- Болд Л.* 1990. БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс. УБ
- Букиннич Д.Д.* 1934. Краткий предварительный отчет мелиоративно-гидротехнической и археологической партии Орхонской экспедиции 1933 г. ТХГБС, д. 17, 4
- Гаврилова А.А.* 1966. Могильник Кудыргэ как источник по истории алтайских племен. М-Л.; Изд-во АН СССР, Т. 2. с. 292-347.
- Гейкель А.О.* 1891. Надписи долины Орхона. Восточное обозрение. Иркутск, 13.с.7-8
- Кирюшин Ю.Ф., Неверов Н.Ф., Степанова Н.Ф.* 1990. Курганный могильник Верх-Еланда I в Горном Алтае. Археологические исследования на Катунь. Новосибирск
- Киселев С.В.* 1949. Древняя история Южной Сибири. М-Л.; Изд-во АН СССР, 362 с. (МИА; '9)
- Клеменц Д.А.* 1895. Краткий отчет о путешествии по Монголии за 1894 г. ИИ АН. СПб., 1895
- Ковычев Е.В.* 1988. Средневековые погребальные памятники из окрестностей станции Оловянная. Памятники эпохи палеометалла в Забайкалье. Улан-Удэ
- Котвич В.Л.* 1914. В Кушо-Цайдаме. Тр. ТКОПОРГО, т. XV, вып. 1. СПб., б. С.50-54.
- Кызласов Л.Р.* 1975. Ранние монголы. с. 170-177
- Мырзатай Жолдасбеков, Сарткожаулы Каржаубай,* 2006.. Атлас Орхонских памятников. Астана
- Радлов В.В.* 1892. Атлас древностей Монголии. вып. I.
- Радлов В.В.* 1892. Атлас древностей Монголии. 1893. вып. II.
- Радлов В.В.* 1892. Атлас древностей Монголии. 1896. вып. III.
- Радлов В.В.* 1892. Атлас древностей Монголии. 1899. вып. IV.
- Сэр-Оджав Н.* 1958. Монгол-чехословакийн эртний судлалын хээрийн шинжилгээний ажлын тухай. ШУТ, б, 15-б. с. 61-68.
- Сэр-Оджав Н.* 1970. Эртний түрэгүүд. УБ
- Ядринцев Н.М.* 1890, 1891, 1892, 1901. Отчет и дневник о путешествии по Орхону и в Южный Хангай в 1891 году. СТОЭ, вып. V. СПб.
- Nakki Asum.* 2000. Year 2000 excavation of Bilge Khan monument. Ankara
- Hallit Gal.* 2000. Year 2000 excavation at anonymous IV symbolic tomb. Ankara

SUMMARY

Z.Batsaikhan

STONE CONSTRUCTION IN SHIVEET UUL

In 2008, the archaeological team excavated a big round tomb dated to the II Eastern Turkic khaganat. The site is located to north from the Kara Korum city and to south from the Bilge khan and general Kultegin monuments. The site is situated on the hilltop in the Orhun valley.

The tomb is 70 m in diameter, 5-7 m high and consisted of external and internal constructions. The internal architectural construction is orientated in the north to south and west to east direction, and each side of the wall is 36 m and 100-200 cm high. During excavation a good conserved stone statue in seating position with legs crossed was discovered. Burial chamber of the grave has not been found and the excavation will be continued next year.

This site provides important archaeological data for the study of ancient Turkic aristocratic tomb system.